

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
АРВАННЭГ ДҮГЭЭР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2024-12-01

Баруун-Урт

Хяналт шалгалтын мэдээлэл:

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2024 онд дэвшүүлсэн зорилт, хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний дагуу Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж түүнийг үндэслэн Төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон дүрэм, журам, стандартын биелэлт, хэрэгжилтэнд хяналт тавьж, тухайн байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад дүгнэлт өгөх илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжлийн заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Аймгийн Засаг даргын баталсан 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 06 тоот дотоод аудитын удирдамжийн дагуу Сүхбаатар аймагт эрх шилжиж ирсэн улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтын 2024 оны төлөвлөгөө, гүйцэтгэлд дотоод аудитын шалгалт хийгдэж байна.

Бусад мэдээлэл:

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны “Дотоод аудиторруудыг чадавхжуулах нь” сэдэвт зүүн бүсийн сургалтыг зохион байгуулсан.

ТАЙЛАН БИЧСЭН:

ДОТООД АУДИТОР

Б.УЯНГАНЯМ